

УЛИАСТАЙ СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

БАТЛАВ

ДАРГА  Б.ЭРДЭНЭБААТАР

Огноо: 2019 оны 8 дугаар сар 5-ны өдөр

**“ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНД ГАРАЖ ХУДАЛДАЖ АВАХ” АЖЛЫН
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ХОТ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНД ГАРАЖ ХУДАЛДАЖ АВАХ

Төслийн дугаар: 01-XA-04/2019

Улиастай сум

2019 он

**Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ
УРИЛГА**

Завхан аймаг Улиастай сум Засаг Даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Хот тохижилт үйлчилгээний албандаа гараж худалдаж авах” тендерийн үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул баримт бичгийг татаж авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 9 дугаар сар 9-ны өдрийн 10 цаг 10 минут-т** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Захиалагчийн хаяг: Завхан аймаг, Улиастай сум, Жинст баг Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын байрны 1 давхар 105 тоот өрөө,
Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
утас: 88466861**

		Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА
1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
	2.3.	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
	(а)	Унийн санал;
	(б)	Унийн бол нийлүүлэлтийн хуваарь;
	(в)	Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
	(г)	Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
	(д)	[Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1.	Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

- | | |
|--------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>7.2. Бараа
нийлүүлэлти
йн хуваарыт
заасан
бараа нь
TШӨХ-ð
заасан</p> | <p>багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал
үнийн санал ирүүлнэ.</p> |
| <p>8. Гэрээ
байгуулах
эрх олгох
тухай
мэдэгдэл</p> | <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад
нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг
харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт
оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| <p>8.1.</p> | <p>Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ
байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх
хугацаа дусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ
мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх
мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ
нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор
нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ
байна.</p> |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх. 2. Захиалагч татварын байгууллага болон бусад холбогдох газруудаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх. 3. Техникийн тодорхойлолтод дүйцэхүйц байх.
ТОӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Улиастай Сум ЗДТГ, Тендер хүлээн авах этгээд: С.Мөнхтулга Байгууллагын хаяг: Завхан аймаг. Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын байр Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар 105 тоот Аймаг, хот: Завхан аймаг. Улиастай сум Шуудангийн дугаар: Байхгүй Улс: Монгол Улс Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 он 09-р сар 09-ны өдөр Цаг: [10 цаг 00 минут]</p>
ТОӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Завхан аймаг. Улиастай сумын Засаг даргын тамгын газрын байр Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар 202 тоот өрөөнд Аймаг, хот: Завхан аймаг. Улиастай сум Шуудангийн дугаар: байхгүй Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 09 дугаар сарын 09-ны өдөр Цаг: [10 цаг 10 минут]</p>
ТОӨЗ 3.1	- Унийн санал
ТОӨЗ 3.1(г)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Үгүй
ТОӨЗ 3.1(д)	<ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулсан ирүүлнэ. Захирал өөрөө гарын үсэг зурж буй тохиолдолд итгэмжлэл шаардлагагүй. 2. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. <p>Жич: Техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 6.1	Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХОТ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНД ХУДАЛДАН АВАХ ДУЛААН ГАРАЖНЫ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. ХАЛААЛТЫН ШУГАМАНД ХОЛБОГДСОН
2. ДОТООД ГЭРЭЛТҮҮЛЭГ СТАНДАРТ ХАНГАСАН
3. АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМТЭЙ
4. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН НОРМ ЖУРМЫГ ХАНГАСАН
5. БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ОВОР ХЭМЖЭЭ / өндөр 4,20м өргөн 12м урт 22м/
 $V= 1000\text{m}^3$, $S=250\text{m}^2$ доoshgүй
6. ЖИНСТ БАГИЙН НУТАГТ ДЭВСГЭРТ БАЙРШИЛТАЙ байх зэрэг
шаардлагуудыг хангасан байна.

ХҮЙТИЙН УЛИРАЛД ДУЛААН ГАРАЖИД ТАВИХ ШААРДЛАГАТАЙ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

1. НОРД-БЕНЗ 20тн
2. УНИВЕРСАЛЬ ТРАКТОР
3. КОВШ АЧИГЧ
4. ГЭРЭЛТҮҮЛГИЙН КРАН
5. САМОСВАЛ газ 53
6. КАНТЕР өөрөө буулгагч
7. ПОРТЕР 4 ширхэг

Гаражийн барилгын үзүүлэлтийг гаргасан:

ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ

АЛБАНЫ ДАРГА

Б.ГАН ЭРДЭНЭ

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮННИЙ САНАЛЫН
МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын
дарга

танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гаралт үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НЭАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

Тендерийн нийт үнэ

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад

нөхцөл: Тендерт

оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факт	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	<p>1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.</p>
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	<p>2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.</p>
3. Оюуны өмчийн эрх	<p>3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.</p>
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	<p>4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.</p>
5. Баталгаат засварын хугацаа	<p>5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [too] жил байна.</p>
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	<p>6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.</p>
7. Төлбөр	<p>7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан too] хоногийн дотор шуурхай хийнэ.</p>
8. Бараа нийлүүлэх х хуваарь	<p>8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.</p>
9. Алданги оногдуулах	<p>9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.</p>
10. Үүргээ биелүүлээг үй-ээс гэрээг цуцлах	<p>10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.</p>

- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)⁴ | 9.1. Алданги оногдуулах хувь:

Алдангийн нийт дүн: |

³ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлберийн хуваарийг өөрчилнэ.

⁴ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁵

БАТЛАВ.

ЗАХИАЛА ГЧ

(Тамга,
тэмдэг)

(Гарын
үсэг)

(Албан
тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]
гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний
дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож
_____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч _____ нэр төрлийн нь барааг _____ оны ____ дугаар сарын ____-аас _____ оны ____ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай
мэдэгдэл; Бусад шаардлагатай
баримт бичиг⁶;
Үнийн санал;
Гэрээний тусгай
нөхцөл; Гэрээний
ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн
хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

⁵ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁶ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт,
өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудангаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал,
нэр] [Гарын үсэг]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын
дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны
дугаар]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын
дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]